


Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2023/38/НА-СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2023 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор Ч.Мөнхтогтох Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,  
E-mail: [uvs@audit.gov.mn](mailto:uvs@audit.gov.mn)

УВС АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.АЛИМАА ТАНАА

2023.03.15 № УВА-2023/38/НА-СТА-ОНӨААН  
ганай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Наранбулаг сумын Эмийн эргэлтийн сан 32,160.2 мянга, Сагил сумын Эмийн эргэлтийн сан 12,136.3 мянга, нийт 44,296.5 мянган төгрөгийн гүйлгээг холбогдох анхан шатны баримтын иж бүрдэл дутуу баримтаар хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн хуулийн заалтад нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0200700669

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн нягтлан бодогч өөрчлөгдсөн байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үзэнэ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>908,108,920.41</b>	<b>933,566,585.98</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>220,011,476.92</b>	<b>157,010,893.05</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>220,011,476.92</b>	<b>157,010,893.05</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>220,011,476.92</b>	<b>157,010,893.05</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	220,011,476.92	157,010,893.05
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>114,142,532.26</b>	<b>72,960,117.76</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>114,142,532.26</b>	<b>72,960,117.76</b>
33510	Байгууллагаас авах авлага	114,142,532.26	72,960,117.76
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>573,954,911.23</b>	<b>703,595,575.17</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>573,954,911.23</b>	<b>703,595,575.17</b>
35130	Эм боох материал	573,954,911.23	703,595,575.17
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,584,664.82</b>	<b>37,629,816.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>45,584,664.82</b>	<b>37,629,816.82</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>42,525,664.82</b>	<b>37,321,816.82</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	7,580,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,521,572.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,055,694.82	157,765,344.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-119,955,748.00	-132,981,333.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,972,608.00	31,798,508.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,546,890.00	-25,320,030.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,059,000.00</b>	<b>308,000.00</b>
39301	Програм хангамж	25,384,964.00	22,399,964.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,325,964.00	-22,091,964.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>953,693,585.23</b>	<b>971,196,402.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>94,314,738.00</b>	<b>116,917,749.95</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>94,314,738.00</b>	<b>116,917,749.95</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>94,314,738.00</b>	<b>116,917,749.95</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>94,314,738.00</b>	<b>116,917,749.95</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	94,314,738.00	116,917,749.95
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>859,378,847.23</b>	<b>854,278,652.85</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>859,378,847.23</b>	<b>854,278,652.85</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	109,472,931.00	109,472,931.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	109,472,931.00	109,472,931.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>749,905,916.23</b>	<b>744,805,721.85</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	674,608,504.80	749,905,916.23
51220	Тайлант үеийн үр дүн	75,297,411.43	-5,100,194.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>953,693,585.23</b>	<b>971,196,402.80</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,900,773,557.07</b>	<b>1,999,823,908.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,900,773,557.07</b>	<b>1,999,823,908.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,900,773,557.07</b>	<b>1,999,823,908.54</b>

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,900,773,557.07	1,999,823,908.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,900,773,557.07	1,999,823,908.54
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,825,476,145.64	2,004,924,102.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,476,145.64	2,004,924,102.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,825,076,145.64	2,004,924,102.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,607,001.00	0.00
210101	Үндсэн цалин	4,069,450.00	0.00
210104	Урамшуулал	537,551.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	500,000.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	500,000.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,233,900.76	873,068.79
210301	Гэрэл, цахилгаан	1,131,542.76	873,068.79
210302	Түлш, халаалт	2,102,358.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,818,280.00	51,625,876.81
210401	Бичиг хэрэг	2,268,650.00	13,143,267.23
210402	Тээвэр, шатахуун	6,585,300.00	14,246,572.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	936,250.00	1,195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363,000.00	6,852,727.58
210408	Бараа материал акталсны зардал	10,665,080.00	16,188,310.00
2105	Нормативт зардал	1,766,829,848.88	1,926,137,729.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,766,829,848.88	1,926,137,729.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,111,000.00	6,640,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,593,750.00
210604	Урсгал засвар	4,111,000.00	3,046,390.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,900.00	114,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	225,900.00	114,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,750,215.00	19,532,588.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,750,215.00	19,532,588.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	75,297,411.43	-5,100,194.38
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	75,297,411.43	-5,100,194.38

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,472,931.00	0.00	674,608,504.80	784,081,435.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,472,931.00	0.00	674,608,504.80	784,081,435.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	75,297,411.43	75,297,411.43
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,472,931.00	0.00	749,905,916.23	859,378,847.23
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,472,931.00	0.00	749,905,916.23	859,378,847.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,472,931.00	0.00	749,905,916.23	859,378,847.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,100,194.38	-5,100,194.38
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	109,472,931.00	0.00	744,805,721.85	854,278,652.85

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,903,883,713.87	1,972,858,054.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,903,883,713.87	1,972,858,054.24
120	Нийтлэг татварын бус орлого	1,903,883,713.87	1,972,858,054.24
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,903,883,713.87	1,972,858,054.24
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,820,547,275.15	2,023,568,088.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,820,547,275.15	2,023,568,088.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,820,147,275.15	2,023,568,088.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,607,001.00	0.00
210101	Үндсэн цалин	4,069,450.00	0.00
210104	Урамшуулал	537,551.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	500,000.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	500,000.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,276,072.76	489,817.91
210301	Гэрэл, цахилгаан	1,173,714.76	489,817.91

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	2,102,358.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,153,200.00</b>	<b>25,141,283.49</b>
210401	Бичиг хэрэг	2,268,650.00	8,827,716.88
210402	Тээвэр, шатахуун	6,585,300.00	12,529,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	936,250.00	1,195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363,000.00	2,589,146.61
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,797,274,101.39</b>	<b>1,997,520,486.71</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,797,274,101.39	1,997,520,486.71
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,111,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	4,111,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>225,900.00</b>	<b>166,500.00</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	225,900.00	166,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>400,000.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>400,000.00</b>	<b>0.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>83,336,438.72</b>	<b>-47,912,260.24</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,779,700.00</b>	<b>12,290,550.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,779,700.00</b>	<b>12,290,550.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,779,700.00</b>	<b>12,290,550.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,779,700.00	12,290,550.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-7,779,700.00</b>	<b>-12,290,550.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>75,556,738.72</b>	<b>-60,202,810.24</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,454,738.20	220,011,476.92
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	220,011,476.92	157,010,893.05

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-аар үйл ажиллагаагаа зохион байгуулдаг Увс аймгийн 18 сумын хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангах, сум, багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,300.7 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	220,011.0	157,010.8	-63,000.2
Авлага	114,142.5	72,960.1	-41,182.4
Бараа материал	573,954.9	703,595.5	129,640.6
Үндсэн хөрөнгө	45,584.6	37,629.8	-7,954.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>953,693.5</b>	<b>971,196.4</b>	<b>17,502.9</b>
Өр төлбөр	94,314.7	116,917.7	22,603.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	859,378.8	854,278.6	-5,100.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>953,693.5</b>	<b>971,196.4</b>	<b>17,502.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 157,010.8 мянган төгрөг болж 63,000.2 мянган төгрөгөөр буурсан нь эмийн нөөц бэлдсэн, цар тахалтай холбоотойгоор ард иргэдийн болон сумдын Эрүүл мэндийн төвийн эм боох материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Авлага дансны үлдэгдэл 72,960.1 мянган төгрөг болж 41,182.4 мянган төгрөгөөр буурсан нь Ковид-19 цар тахлын үед Эрүүл мэндийн төвүүд өрийг төлснөөр авлага хорогдсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 703,595.6 мянган төгрөг болж 129,640.7 мянган төгрөгөөр өссөн нь Эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 37,321.8 мянган төгрөг болж 7,262.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 116,917.7 мянган төгрөг болж 25,603.0 мянган төгрөгөөр өссөн нь Эмийн эргэлтийн сангийн нөөц бүрдүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 854,278.6 мянган төгрөг болж 2,302.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлан оны үр дүнгээс шалтгаалсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн эргэлтийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Увс аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн эргэлтийн сангийн орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаа Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 116 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,825,476.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 9,127.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,004,924.1

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит мянган төгрөгийн 0.5 хувь болох 10,024.6 мянган төгрөгийн 80 хувиар буюу 8,019.6 мянган төгрөгөөр тогтоосон.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуулийн Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн санд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 130, хугацаа хоцроосон 19 мэдээлэл, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 4,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 400.0 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн 77.7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,500.0	1	2,500.0	55.5
Албан шаардлага	1	400.0	1	400.0	100.0
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>4,900.0</b>	<b>2</b>	<b>2,900.0</b>	<b>77.7</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,296.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 44,296.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 5.3 Зөвлөмж

##### Илрүүлэлт:

Наранбулаг сумын Эмийн эргэлтийн сан 32,160.2 мянга, Сагил сумын Эмийн эргэлтийн сан 12,136.3 мянга, нийт 44,296.5 мянган төгрөгийн гүйлгээг холбогдох анхан шатны баримтын иж бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу	1	44,296.5					1	44,296.5				
Дүн	1	44,296.5					1	44,296.5				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.ВАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.ВАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 03 сарын 15-ны өдөр